



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/29

Баян-Овоо сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Эрүүл ахуйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.7, 11.1.8, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2, 25.2.2 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын төвийн эзэнгүй нохой муур устгах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Отгонбаяр

Жавхлант багийн Засаг дарга

Нарийн бичгийн дарга: Г.Шижирбаатар

Тархвар зүйч

Гишүүдэд:

Б.Баасанням

Жолооч

2. Нохой муур устгах ажилд зарцуулагдах 2,335,000 (Хоёр сая гурван зуун гучин таван мянган) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын нэмэлт данснаас холбогдох хууль, журмын дагуу зарцуулахыг Нягтлан бодогч (Э.Уранбайгаль)-д үүрэг болгосугай.

3. Эзэнгүй нохой муур устгах ажлыг зохион байгуулан, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгч гарын үсгээр баталгаажуулан ажиллахыг багийн Засаг дарга (С.Отгонбаяр), ариутгал халдваргүйжүүлэлтийг хууль, журмын дагуу хийж гүйцэтгэхийг Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч (Г.Шижирбаатар) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ЦОЛМОНБЯАР

Сумын Засаг даргын 20 ~~26~~ оны 03 дугаар
сарын 13 -ны өдрийн 422 тоот
захирамжийн I хавсралт



НОХОЙ, МУУР УСТГАЛЫН ТӨСӨВ

Д/д	Материал	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт дүн
1	Нохой	35	25000	875,000
2	Муур	38	30000	1,140,000
3	Сум	100	3200	320,000
Нийт дүн				2,335,000